



**НИЙСЛЭЛИЙН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

Г Дотоод хяналт шалгалтыг зохион Г  
байгуулах журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалтууд, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлэн ажиллахыг дотоод хяналт хариуцсан ажилтан Б.Хэнмэдэхэд үүрэг болгосугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ХЭРДЭНЭБИЛЭГ

1150500046

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын  
даргын 2021 оны 09 дугаар сарын 09-ны  
өдрийн 123 дугаар тушаалын хавсралт



## БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журмын зорилго нь Нийтлэг үйлчилгээний газрын / цаашид “газар” гэх / үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Газар нь дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” болон энэхүү журмыг удирдлага болгоно.

Хоёр. Дотоод хяналт шалгалтын зорилго, зарчим, хамрах хүрээ

2.1 Дотоод хяналт шалгалтын зорилго нь: Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагаа Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, төрийн албан хаагчдад үзүүлж буй үйлчилгээ нь батлагдсан норм, стандарт болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн дутагдлыг арилгах, байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

2.2 Дотоод хяналт шалгалт нь ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.

2.3 Дотоод хяналт шалгалтыг тодорхой бус гомдол, овог нэр хаяггүй мэдээллээр явуулахгүй байх

2.4 Дотоод хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

2.5 Байгууллагын бүх хэлтэс, алба, нэгж, ажилтан, албан хаагчид энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2.6 Газрын дотоод хяналт шалгалтыг захиргааны асуудал хариуцсан хэлтсийн дарга болон дотоод хяналтын ажил хариуцсан ажилтан /цаашид дотоод хяналт шалгалт хариуцсан нэгж гэх/ тус тус гүйцэтгэнэ.

2.7 Шаардлагатай тохиолдолд газрын тушаалаар дотоод хяналт шалгалтын комисс томилон ажиллуулах бөгөөд бүрэлдэхүүн нь төр захиргаа, хууль эрх зүйн болон санхүүгийн зохих мэдлэгтэй, газрын үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байвал зохино.

Гурав. Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтны эрх, үүрэг

3.1 Газрын даргын тушаалаар байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгж буюу ажилтанг томилон ажиллуулах бөгөөд хууль эрх зүйн болон санхүүгийн зохих мэдлэгтэй байвал зохино.

3.2 Дотоод хяналт шалгалтын нэгж буюу ажилтан нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1 дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь байгууллагын удирдлага, захиргаанд шууд удирдагдах бусад алба, нэгжээс хараат бус байна.

3.2.2 газрын даргын баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэх;

3.2.3 хяналт шалгалт явуулахдаа хэлтэс, албадуудын удирдлагуудтай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах;

3.2.4 илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцлийг тодруулан арилгах, дахин гаргуулахгүй байх арга хэмжээ авах, шаардлага тавих, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;

3.2.5 Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт, байгууллагын дүрэм, журмыг өөрийн байгууллагын ажилтан, албан хаагчдад сурталчлах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах;

3.2.6 дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлэхэд, дүгнэлт гаргуулах, хамтран ажиллах;

3.2.7 хяналт шалгалт хийхэд холбогдох албан тушаалтнуудыг татан оролцуулах;

3.2.8 байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр мөрдөгдөх холбогдох хууль, дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох талаар судалгаа, дүгнэлт хийх, санал гаргах;

3.2.9 дотоод хяналтын материалыг байгууллагын архивд архивын нэгж болгон хадгалуулах;

3.2.10 байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаархи мэдээллээр удирдлагыг хангах;

3.2.11 хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн мөрөөр ажиллаж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах талаар зөвлөмж өгч ажиллах;



3.2.12 зөвлөмжөөр өгсөн хэрэгжилтийн мэдээ, тайланг даргын зөвлөлийн хурлаар танилцуулж хэлэлцүүлэх;

Дөрөв. Дотоод хяналт шалгалтын чиглэл, үйл ажиллагаа

4.1 Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна. Үүнд:

4.1.1 нутгийн захиргааны байгууллагуудад үзүүлж ажил үйлчилгээний чанар хүртээмжид тавих хяналт;

4.1.2 хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагын хэрэгжилтэд тавих хяналт;

4.1.3 байгууллагад ажиллаж буй хэлтэс, албадуудын үйл ажиллагаа;

4.1.4 байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа авто тээвэр, эрчим хүч, барилга байгууламжийн аюулгүй байдал;

4.1.5 ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ёс зүй, төлөвшилд тавих хяналт;

4.1.6 өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт;

4.1.7 хоол үйлдвэрлэл, хоол цайны үйлчилгээний заавал мөрдөх стандарт, технологийн горимын мөрдөлтөд тавих хяналт;

4.1.8 бэлтгэн нийлүүлж байгаа түүхий эд, бараа бүтээгдэхүүний чанар, хадгалалтын горимын мөрдөлтөд тавих хяналт;

4.1.9 шаардлагатай бусад хяналт шалгалт;

4.2 энэхүү хяналт шалгалтыг дотоод хяналт хариуцсан нэгж буюу ажилтан хариуцан гүйцэтгэнэ;

#### Тав. Хариуцлага

5.1 Байгууллагын удирдлага нь дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтны саналыг үндэслэн, дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын дагуу буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг ногдуулна.

5.2 Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг холбогдох хууль, хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.